

Түвшинширээ сумын 2021 оны 10 дугаар сарын ажлын товч мэдээ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар болон аймгийн Засаг даргын захирамжууд, аймгийн Онцгой байдлын газраас өгсөн цаг үеийн холбогдолтой үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сумын шуурхай штаб нь сумын Засаг даргын 2021 оны А/86 дугаар “Шуурхай штаб шинэчлэн байгуулах тухай” захирамжаар шинэчлэн байгуулагдаж 24 цагаар жижүүлэн ажиллаж байна.

2021 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлага сумын Засаг даргын 2021 оны А/101 “2021 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу зохион байгуулагдаж, 18-28 насны 77 иргэнд зарлан дуудах хуудас тарааж, 53 залуу үзлэгт хамрагдаж, 8 залуу цэргийн жинхэнэ албанд татагдлаа.

2021 оны 10 дугаар сарын байдлаар сумын нийт хүн ам 3443, сумын нийт өрх 977, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн хүүхэд 10 дугаар сарын байдлаар 56, нас барсан 14 хүн бүртгэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2021 оны 09 дүгээр сараас эхлэн даваа гараг бүр COVID-19 цар тахлаар өвчилсөн хүүхдүүдийн түргэвчилсэн үнэлгээ болон, судалгаа тайланг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлж байна.

Багийн Засаг дарга нар цар тахал, цаг үеийн болоод цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тухай бүр нь цахим сүлжээгээр болон утсаар иргэд малчдад мэдэгдэн ажиллаж байна. Багийн болон сумын нийт ард иргэдэд банкны болон холбогдох тодорхойлолтуудыг гаргаж өгч, төрийн үйл ажиллагааг тасралтгүй хүргэн ажиллаж байна.

Нягтлан бодогч нар төсөвт байгууллагуудын 3-р улирлын санхүүгийн тайланг гаргаж Э-тайланд шивж илгээсэн. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого болохтой холбогдуулан холбогдох маягтын дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа, тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй өөр аймаг, Улаанбаатар хотын бүртгэлтэй аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж Статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын төвийн хогийн цэгийг цэгцлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Элимент медикал” ХХК-г шалгарч гэрээ байгуулах эрх олгогдон, сумын төвийн хогийн цэгийг цэгцлэх ажлын гүйцэтгэл 98%-тай явагдаж байна. Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн 60 га газрын хог хаягдлыг ландфилийн аргаар булаж устгах ажлын хүрээнд хогийн нэгдсэн цэгийн талбайн хэмжээг тогтоож, хог хаягдлын эзэлхүүнийг нисдэг камер ашиглан тогтоож, ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

Хогийн нэгдсэн цэгийн талбайн хэмжээг одоо байгаа хэмжээнээс 2.5 дахин буюу 8-10 га талбай болгон багасгах зорилт тавин хог асгах 40х40 харьцаатай 4 метрийн гүнтэй нүх, бохир хийх 2х2 харьцаатай 3 метрийн нүх, мал нядалгааны газруудын хог хаягдал хийх 4х2 харьцаатай 3 метрийн гүнтэй нүх ухаж эмнэлгийн аюултай хог

хаягдал цэгийг стандартын дагуу тохижуулж тэмдэг тэмдэглэгээ бүхий самбар байршуулах, хог хаягдал ачиж тээвэрлэх хуваарь гаргах зэрэг ажлууд хийгдээд байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн сумын төвийн камержуулалтын ажил 100% хийгдэж, ажлын комисс хүлээн аваад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Нэг тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд нэгдэж Түвшинширээ сумын хэмжээнд 800 ширхэг хайлаас, 120 ширхэг улиас, Жимсний мод 10- ширхэгийг 10 сарын 15 ны өдрөөс эхлэн мод тарих ажлыг зохион байгууллаа.

Уул уурхайн ашиглалтын “Жи Би Эм” ХХК нь хуулиар олгогдсон тусгай зөвшөөрлийн талбайдаа хайгуулын ажлыг хийж гүйцэтгэх явц нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцаж, 10 сарын 4 нөөс 11 сарын 4 хүртэл хугацаатай ус ашиглах гэрээ байгуулсан.

Монгол улсын байгаль орчин аялал жуулчлалын сайдын 02 албан даалгаврын хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн А/243 тушаалыг хэрэгжүүлэн сумын хэмжээнд мөрдөн ажиллах хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг ИТХ-аар шинэчлэн тогтоож Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн улсын нэгдсэн бүртгэлийн 5411 дугаарт бүртгэснийг мэдэгдсэн.

Үнэгд багийн төвийн нэгдсэн хогийн цэгийн хог хаягдлыг булаж устгах, багийн иргэдэд ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, Өлзийт багийн нутагт дэвсгэрт үүссэн хур хог хаягдлыг зөөвөрлөн нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх ажлыг хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 221 дүгээр тогтоол, Монгол Улсын шадар сайд ХХААХҮ-ийн сайдын 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын А/454 тоот захирамж, 07 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үүднээс Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 05 сарын 10- ны өдрийн А/71 дүгээр тушаалаар баталсан Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах албан даалгаврын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Тус суманд энэ өвөл 998 өрхийн, 314,0 орчим мянга толгой мал өвөлжих урьдчилсан тооцоо гараад байна. Хэнтий аймгийн нутагт 10 өрхийн 11200 бог, 800 бод өвөлжихөөр байна. Өөрийн аймгийн бусад суманд 8 өрх 7300 бог, 3200 бод өвөлжихөөр байна.

Малчид байгалийн хадлан бэлтгэх боломжгүй хэдий ч гар тэжээлийг өөрсдийн боломж бололцооны хүрээнд 8,2 тн-ыг, бэлтгэсэн өвс 120тн авсан байна.

Малын төлөвлөгөөт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил цаг хугацаандаа хийгдэж одоогийн байдлаар ямар нэгэн хүндрэл үүсээгүй байна.

Сумын хэмжээнд 3 гүн өрмийн худгийг малчдын хөрөнгө оруулалтаар гаргаж хүлээн аваад байна.

Өгөөмөр багийн нутаг Бор цав, Зараа уул, Хөндий, Халзан уул орчмын 48,0 мянган га газар нутгийг 7 дугаар сарын 20-ноос хойш малын хөлөөс чөлөөлж хамгаалаад байна.

Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үржлийн мал сүргийг жилд 1-ээс доошгүй удаа үзлэг ангилалтанд хамруулж, ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 520 хуц, ухныг үзлэг ангилалтанд хамруулж ээмэгжүүлсэн. Сумын хэмжээнд дутагдалтай байгаа хээлтүүлэгч малыг малчид хувь хүмүүст зуучилсны үр дүнд Эрдэнэцагаан сумаас үзэмчин хуц 70, Баяндэлгэрийн улаан ухна 65, Түмэнцогтын мах сүүний чиглэлийн 5 бухыг малчид өөрсдийн хөрөнгөөр худалдан авч дутагдалтай хээлтүүлэгчийн нөхөж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/464 тоот захирамж, сумын Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/79 тоот захирамжийн дагуу сумын хэмжээний охин төл малд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг хийж дуусгалаа.

Сумын хэмжээнд 86600 толгой мал вакцинжуулалтад хамрагдахаас 5 багийн 669 өрхийн хурга 47021, ишиг 34599, тугал 4259, бүгд 85879 толгой мал хамрагдаж, 85,879 тун вакцин зарцуулсан байна.

Мөн орон нутгийн санхүүжилттэй 9 төрлийн вакцинжуулалт хийгдэж дуусч байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мал угаалгын ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар 52500 толгой мал угаалгад хамрагдаж мал эмнэлгийн цахим системд шивэгдэж орсон байна. Боловсруулалтад 7500 толгой мал хамрагдагдаж нэгдсэн системд орсон байна.

2021 оны 10 сард мал эмнэлгийн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 26 өрхийн 650 толгой мал үзлэгт орсон байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд ажлын байранд 15 иргэн, шинэ ажлын байранд 14 иргэний мэдээллийг бүртгэсэн.

2017-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрт хамрагдсан 6 иргэн 4200,0 төгрөгийг дансанд төвлөрүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төсөл хөтөлбөрт хамрагдсан 3 иргэнийг аймгийн үзэсгэлэн худалдаанд хамруулсан.

Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөлд 5 иргэн хамрагдсан, үүнээс 4 иргэн дадлага хийсэн ба дадлагын тайлан, холбогдох баримтыг бүрдүүлэн өгсөн.

Аж ахуй эрхлэлтийн цахим сургалт болохтой холбогдуулан 3 иргэний нэрийн жагсаалтыг гарган өгсөн.

Нийгмийн халамжийн хугацаагүй хугацаагаар тэтгэвэр авч буй 15 иргэний судалгааг гаргасан.

2021 оны 10 сард Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 4 иргэнд 740613 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгсөн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний олголт шинэ программд шилжсэнтэй холбогдуулан гэрээт дэлгүүр одоогоор 11 өрхөд олголтыг хийж байна. Нийт сумын хэмжээнд 22 өрхийн 98 иргэн хамрагдаж байгаа ба 10-р сарын 1,208,000 төгрөгийн "Хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бүртгэл",-ийг гэрээт дэлгүүрт бэлтгэн өгч өрхүүдэд олгуулж байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ халамжаас хөдөлмөрт хүрээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, иргэдийн дэлгэрэнгүй судалгааг маягтын дагуу хагас жилээр тус тус гаргасан.

Ахмадын баярын тохиолдуулан сумын хэмжээнд нийт 277 ахмад настан үүнээс байгууллагын харьяалалтай 47 ахмад, харьяалалгүй 230 ахмадын судалгааг гарган, нэрийн дансаар мөнгөн урамшуулалд хамруулсан.

Нийгмийн халамжийн ehalamj системд 6 хүүхдийн баримт бичгийг хүлээн авч бүртгэсэн.

10-р сард Нийгмийн халамжийн ehalamj системд Нийгмийн халамжийн тэтгэвэрт-1 иргэн, сунгалт 2 иргэн, Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 6 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 7 иргэнд, шүдний хөнгөлөлт 1 ахмад, түлээний хөнгөлөлт-22 нийт 39 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэмжид хамруулсан.

Боловсролын чиглэлээр: ЕБС: 2021 оны 10-р сард сургуулийн сургалт 5:9-өөр зохион байгуулагдлаа.

Ирээдүйн эзэд-2021 мэргэжил сонголтын аяны хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас санаачлан 2021 оны 10-р сарын 2 нд зохион байгуулсан “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?” цахим сургалтад 8-12-р ангийн 24 сурагч оролцлоо.

Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан “Сургуульд суурилсан үнэлгээ”-г нийт 308 сурагчид 16 судлагдахуунаар хамрагдсан. 247 хүүхэд танхимаар, 61 хүүхэд цахимаар хичээллэж байна.

Аймгийн ГБХЗХГазар, Зэвсэгт хүчний 338-р ангийн албан хаагчид хамтран аймгийн хэмжээнд “Энхийг сахиулагчид ба хөвгүүд” цахим сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад 6-9 дүгээр ангийн 8 суралцагч хамрагдлаа.

Охидын эрхийг хамгаалах өдрөөр аймгийн ГБХЗХГазар, аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхэд, өсвөр үеийн их эмч Т.Мөнхмөрөн нар хамтран ахлах ангийн охидод “Охидын үнэ цэнэ” цахим сургалтыг зохион байгууллаа.

Сургуулийн сурагчдын оролцооны байгууллага болох “Сурагчдын өөрөө удирдах зөвлөл”-ийг шинэчлэн байгууллаа. Анги бүлгийнхээ манлайлагч бага, дунд, ахлах ангийн нийт 24 сурагчийг сургуулийн “Сурагчдын өөрөө удирдах зөвлөл”-д оруулж шинэчлэн байгууллаа. Энэ ажлын хүрээнд сурагчдын өөрөө удирдлагын байгууллагын лого, дүрэм, танилцуулга зэргийг шинэчлэн баталлаа. Сургуулийн сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн гишүүд болох анги бүлгийн дарга нар МУ-ын

ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж 24 ширхэг мод тарилаа.

Сургууль орчныг цар тахал Ковид-19 халдварт өвчнөөс сэргийлэхэд анхаарч багш, ажилтан, сурагчдыг өглөө бүр ариутгаж, халууныг хэмжиж, QR цахим үнэмлэхийг уншуулж оруулж хэвшлээ. Энэ хүрээнд сургуулийн төгсөгч нараас “Ариутгалын хаалга” сургуульд хандивлаж түүнийг дотуур байранд байршууллаа.

12-р ангийн сурах бичгийг нийт 26 хүүхдийн 234 ширхэг номын Сүхбаатар аймгаас татан авлаа.

Цэцэрлэг: 2021-2022 оны хичээлийн жилийн хамран сурах хүүхдийн нарийвчлан гаргаж, хамран сургах тойргийн болон тойргийн бус 5 настай - 89 хүүхэд, 4 настай 50 хүүхэд нийт 139 хүүхэд танхимаар, 4 настай 37, 3 настай 28 хүүхэд зайнаас хичээллэж байна. Зайны сургалтад хамрагдаж буй хүүхдүүдэд цахим болон цаасан даалгаврыг хүргүүлж, эцэг эхчүүдэд зөвлөгөө зөвлөмж хүргэн эргэх холбоотой ажиллаж байна. Түр журмын дагуу бүлэг зохион байгуулалтыг 1 бүлэгт 25 хүртэлх хүүхэдтэйгээр 6 бүлэг хичээллэж байна. 2-3 настай хүүхдүүдийг хүлээн авахад бэлэн, анги танхим, багш нарын нөөц хүрэлцээтэй. Нийт багш ажилчид “Угийн бичиг - Үндэсний дархлаа”, “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтуудад хамрагдлаа.

ЭМС-ын тушаалын дагуу бүх багш ажилчид урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд Мөнххаан суманд очиж 100% хамрагдсан.

4, 5 настай цэцэрлэгт хамрагдах бүх хүүхдүүд цагаан хорхойн болон урьдчилан сэргийлэх үзлэгт 100% хамрагдсан. Ундны усны шинжилгээ 4,8 сард 2 удаа хийлгэсэн.

Байгууллагын ариутгал халдваргүйтгэлийг “Сайхан жил” нөхөрлөлөөр 700000 мянган төгрөгөөр хийлгэж, халдвар илэрсэн болон ойрын хавьтал илэрсэн тохиолдол бүрт, мөн 5 дахь өдөр бүр их цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэл тогтмол хийж байна. Мөн сумын мал эмнэлгээр гадна талбайг ариутгуулж, байгууллагын эзэмшлийн талбайн орчны цэвэрлэгээг 14 хоног тутамд 1 удаа хийж байна. 2ш мананцаржуулагч, ариутгагч, амны хаалт ариутгалын бодис, амны хаалт, хүүхдийн нэг удаагийн амны хаалтын бүрэн нөөцтэй.

Тандалтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж байнгын бэлэн байдлыг хангуулж цэцэрлэгийн гаднаас хүүхдээ хүлээн авах, зай барих, маскаа тогтмол зүүх, байгууллагад гадны хүн оруулахгүй байх, гар ариутгалыг тогтмол хэрэглэж хэвших, хүүхдийг масктай оруулахгүй, хүүхдийг өглөө, өдөр, орой амыг зайлуулах, ойрын хавьтлыг нарийн тодорхойлох, тусгаарлах өрөөг бэлэн байлгах, нөхцөл байдлын мэдээг тогтмол өгөх ариутгалын нөөц бүрдүүлэх зэрэг ажлуудыг хариуцуулан хийлгэж байна.

Хүүхдийн хөгжил төлөвшилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүлэг бүрийн дотоод группээр мэдээ мэдээллийг цаг алдалгүй өгөх танхим зайнаас суралцах хүсэлтийн дагуу даалгаврын санг бүрдүүлж хүүхэд эцэг эх нэг бүртэй ажиллаж байна. Бүлэг бүрт 5,6 хүүхэд зайгаар даалгавар аван сурч байна. Мөн багш хүүхэд бүр QR кодоор мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдэж код бүрийг эцэг эхэд нь өгч ажиллаж байна. Хичээл ариун цэврийн хэрэгслийг өөрийн аяга халбага, алчуурыг хэрэглэхэд

эцэг эх, дотоод хяналтын ажлын хэсэг тогтмол хянаж хяналтын хуудсаар ажиглаж хэвшлээ.

Сумын үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж хүнсний нөөцөө татан авах, гаднаас ирж буй барааг дотоод хяналтаар хянуулж, гадна ариутгал хийж оруулах, тоног төхөөрөмжийг зориулалтын шингэн содын уусмалаар угааж ариутгаж, тогтмол хяналт хийж хэвшлээ. Хоол хүнсний 21 хоногийн нөөцтэй.

Багш ажилтны ёс зүйн багийг шинэчлэн сургалт зохион байгуулж хөдөлмөрийн гэрээ болон, ёс зүйн батламжаа шинэчлэн ажиллалаа.

Бүх анги танхимын халаалт дулаан хэвийн, гэрээт байгууллагаас 67 тн нүүрс татан авч, хийт багш ажилчдад 1 тн буюу 30 тн нүүрсийг олголоо. Одоогийн байдлаар 21 хоногийн түлээний нөөцтэй, зуух мотор хувийн ажиллаж байна.

Боловсрол ногоон төгөл дэх мод болон өөрийн хариуцсан талбайн модыг 7 хоногт 2 удаа услан тарьж ургуулж, нэмэлтээр 30 ширхэг улиас модыг нэмж суулган, намрын цэнэг усалгаа хийлээ.

Байгууллагын нээлттэй утас ажиллуулахад ямар нэгэн санал гомдол ирээгүй.

Соёл: Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Номын баярын өдөр тэмдэглэх” тухай зарлигийн дагуу номын сан нь дараах ажлуудыг цахимаар хийж гүйцэтгэлээ. 2021 оны хагас жилд үйлчлүүлсэн уншигч нараасаа хамгийн олон ном уншсан 3 уншигчийг “Идэвхтэн уншигч”-аар шалгаруулан “Талархал, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Соёлын тухай, Гэр бүлийн тухай хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн заалтуудыг тус тус үндэслэн сумын өрх айл, иргэн бүрийг угийн бичигтэй болгох, үр удамдаа өвлүүлэн хөтлүүлдэг заншилд сургах, зорилгоор “Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя” уралдааныг ЗДТГ-тай хамтран зохион байгуулахаар болж удирдамжийг албан байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд хүргүүлээд байна. Уг ажлын хүрээнд өөрийн болон бусад байгууллагын ажилтан албан хаагч нарт “Угийн бичиг”-ийг хэрхэн хөтлөх талаар анхан шатны сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Боловсрол Соёл урлагийн 100 жилд зориулж “Бидний бахархал цуврал” 1,2 – ыг байгууллагын цахим хуудсанд байршуулж ард иргэдэд танилцуулж байна. Уг цуврал 1 – ээр соёлын төвийн үе үеийн удирдлагуудын намтар түүх уран бүтээлийн талаар цуврал 2- оор нутгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагч, дуучид, урлаг соёлын алдартнуудыг сурталчлан танилцуулж байна.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 174, алсын дуудлага 11, гэрийн дуудлага 9, хэвтэн эмчлүүлэгч 2, улаан бүсэд хэвтэн эмчлүүлэгч -9, Нас баралт 0.

10 дугаар сард Коронавирусын гоц халдвар 215 ширхэг бүртгэгдээд байна. Уг голомтод бүсэд 2 баг 10 хоногоор ээлжлэн ажиллаж байна. 10-р сард нийт 482 хүнээс шинжилгээ авсан байна.

Хууль эрхзүйн чиглэлээр:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийн талаар нийт 300 ширхэг гарын авлагыг бэлтгэж иргэдэд тарааж байна.

Тайлан нэгтгэсэн:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг